

**БАТЛАВ:**

БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-Н ДАРГА:

Б.БУЯННЭМЭХ

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

"ХАН ИМПЕРИАЛ" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

З.ЗОЛБАЯР

**ХХААХҮЯ-НИЙ ЗАХИАЛГААР АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ  
ХҮНСНИЙ НОГООНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ БА УСАЛГААТАЙ ХӨДӨӨ АЖ  
АХУЙ ТӨСЛӨӨС ЗАВХАН АЙМГИЙН УЛИАСТАЙ СУМЫН НУТАГТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ "НОГООН ХАШАА УСАЛТЫН СИСТЕМ"  
ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ "ХАН ИМПЕРИАЛ" ХХК-НЫ 2022 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5329965/

**ХЯНАСАН:**

БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-Н МЭРГЭЖИЛТЭН:

П. ШИНЭЦЭЦЭГ

**БОЛОВСРУУЛСАН:**

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨНИЙ

"ГЛОБАЛ ЭНВАЙРОН" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Ч.ДАВААСҮРЭН

Улаанбаатар хот

2023 он

## АГУУЛГА

ОРШИЛ.....	4
1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
2.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	10
3.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	13
4.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	15
5.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
6.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
7.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
8.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
9.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
10.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	31
11.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	38
12.ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	40

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршил / байрзүйн зурагт буулгаснаар / .....	6
Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал /2022-08-10/.....	6
Зураг 3. Усгалтын системийн ерөнхий төлөвлөгөө (M1:20000).....	8
Зураг 4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн цэгүүдийн байршил .....	37

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим .....	14
Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ .....	27
Хүснэгт 3. Хог хаягдлыг зайлуулах арга хэлбэр .....	28
Хүснэгт 4. Лабораторийн шинжилгээний тариф.....	31

## ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Захиалагчийн хүсэлтээр "Глобал Энвайрон" ХХК нь "Хан Империл" ХХК-ний Завхан аймгийн улиастай сумын нутагт гүйцэтгэгчээр ажиллаж буй "Ногоон хашаа услалтын систем" төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОННУ, Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, төслийн талбай дээрх 2022 оны хээрийн судалгаа, шинжилгээний дүн, БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тушаал "Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" зэрэг эрх зүйн баримт, материалууд дээр үндэслэн боловсруулав.

"Хан Империл" ХХК нь ХХААХҮЯ-ний захиалгаар Азийн хөгжлийн банкны Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслөөс Завхан аймгийн Улиастай сумын нутагт хэрэгжүүлж буй "Ногоон хашаа услалтын систем" төслийн гүйцэтгэгчээр ажиллаж байгаа юм. Тус төслийн БОННУ-ний тайланг 2021 онд байгаль орчны үнэлгээний мэргэжлийн "Грийн натур ланд" ХХК хийж гүйцэтгэн БОАЖЯ-аар батлуулсан болно.

Энэхүү төлөвлөгөөгөөр "Ногоон хашаа услалтын систем" төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж тэднээр хэлэлцүүлсний дараа, жил бүр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг нэгтгэн хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн үр дүнгийн тайланг тухайн оны 12-р сард багтаан БОАЖЯ-нд ирүүлж, дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлын хэмжээг батална.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Төслийн нэр:** Ногоон хашаа усжуулалтын систем

**Төслийн дугаар:** 2021/Е131

**Төслийн зорилго:** Энэхүү төслийн үндсэн зорилго нь услалтын системийг сэргээн засварлах замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд оршино.


**Төслийн ач холбогдол:** Усалгааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, нутагшуулах, ногоочид, тариаланчдын чадавхи, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, шинээр ажлын байр бий болгон орон нутгийн болон орон нутгийн бус 20-30 хүнийг ажлын байраар хангах болно.

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:** "Хан Империл" ХХК.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 49, 1301 тоот  
Утас: 88888330, 88101653

### Төслийн талбайн байршил

"Ногоон хашаа" услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь Завхан аймгийн Улиастай сумын нутаг дэвсгэрт, сумын төвөөс баруун зүгт 450 метрийн зайд оршино. Улиастай сум нь баруун талаараа Завхан аймгийн Дөрвөлжин сумтай, баруун хойд, хойд, зүүн хойд талаар Завхан аймгийн Яруу, Идэр сумдтай, урд талаараа Завхан аймгийн Цагаанхайрхан сумтай тус тус хиллэдэг.



Зураг 1. Төслийн байршил / байрзүйн зурагт буулгаснаар /



Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал /2022-08-10/

### Усалтын системийн өнөөгийн байдал

"Ногоон хашаа" усалтын системийн анхны зураг төслийг 93 га талбайг услахад зориулж 1974 онд Монгол Улсын Усны аж ахуйн яамны харьяа Усны хайгуул, төсөл, эрдэм шинжилгээний институтэд боловсруулж, 4.4 км урт гол сувагтай, 2.3 км урт доторлогоогүй хуваарилах суваг бүхий усалтын системийг байгуулсан байна.

Харин одоогийн байдлаар 64 га талбайд тариалалт хийдэг бөгөөд Чигэстэйн голоос дөхүүлэх сувгаар усаа татаж голын баруун эрэг дээр байрладаг толгойн барилгаар гол суваг уруу усаа дамжуулдаг. Гол суваг нь доторлогоотой байсан боловч одоо эвдэрч муудсан байна. Илүүдэл ус толгойн барилгын зүүн далд байрлах сувгаар гол уруу нийлнэ. 603 м урт гол сувгийг В10 маркийн цементээр доторлож ус үл нэвтрэх нийлэг хальс дэвссэн байна. Толгойн барилгаас талбай хүртэл 7 м түрэлтийн зөрүүтэй. Сувгийн суурийн өргөн 0.6 м, трапец хэлбэртэй, хажуугийн налуу 1:1.5. Сувгийн доторлогоотой нөхцөлийн урсгалын хурд 2.0 м/с дагууд ус авах хоолой төлөвлөсөн. Илүүдэл ус талбайн төгсгөлийн 3 хэсэгт доторлогоогүй зайлуулах сувгаар хаягдана.

### Төслийн төлөвлөлт, хүчин чадал

Энэхүү төсөл нь үндсэндээ 2 үе шаттай хэрэгжинэ. Үүнд:

1. Усалтын системийн барилгын ажил (Усалтын системийн толгойн барилга, усан сангийн барилга байгууламжийг шинэчлэн барих, усалгааны тоног төхөөрөмжийг угсрах, ус татах, дамжуулах хоолойг суурилуулах г.м);
2. Усалтын системийг ашиглалтанд хүлээн авч 64 га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоог усалгаатай тариалах;


### Усалтын системийн барилга угсралтын ажлын ерөнхий төлөвлөгөө

Ногоон хашаа усалтын системийн (ТЭЗҮ-д зааснаар) 64-га талбайг аригийн усалгаатайгаар ашиглахаар төлөвлөсөн. Уг талбайн байрлал, зохион байгуулалт, орон нутгийн иргэдэд газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн байдал зэргээс хамааран нэгдсэн байдлаар тоног төхөөрөмж ашигласан усалгааны өөр шийдэл сонгоход хүндрэлтэй учир аригийн усалгааны хэлбэрийг сонгосон.

Хуучин ус авах сувгийн эхлэл хэсэгт Чигэстэй голын гольдролд зарцуулгын найдвартай байдлыг хангах зорилгоор түвшин өргөх чулуун далан төлөвлөсөн. Хуучин дөхүүлэх сувгийг шинэчлэн 530 м урт доторлогоогүй дөхүүлэх сувгаар усаа татаж голын баруун эрэг дээр байрлах толгойн барилгаар усалтын системийн талбай руу усыг нийлүүлнэ. Гол суваг нь 603 м урт, доторлогоотой байсан боловч одоо эвдэрч муудсаныг бүрэн шинэчилнэ. Илүүдэл ус толгойн барилгын зүүн далд байрлах сувгаар гол уруу нийлнэ.

Гол сувгаас 2 хуваарилах сувгаар салаалж, усалтын системийн талбай дундуур 5 салбар сувагт хуваан хүртээмжтэй байдлыг харгалзан салбар сувгуудын





**Зураг 3. Усалтын системийн ерөнхий төлөвлөгөө (М1:20000)**

### Ажиллах горим

Усалтын системийн барилга, угсралтын ажлын үед нийт 20-30 хүнийг ажлын байраар ханган ажиллуулна. Нийт ажилчдын 10 нь компаний үндсэн ажилчид байх бол 20 орчим нь түр хугацаанд ажиллах гэрээт ажилчид байна. Гэрээт ажилчдын Улиастай сумын иргэдээс хангахаар төлөвлөсөн. Ажилчдыг өдөрт 10 цагаар ажиллуулах ба усалтын системийн талбайгаас баруун хойд зүгт 6 орчим км-ийн зайд орших түр кемпед байрлуулна. Ажилчдын кемпийн зориулалтаар 1.9 га талбайг түрээслэн ашиглахаар төлөвлөсөн бөгөөд ажилчдын цайны газар, амрах байр, ариун цэврийн өрөө, бие засах газар гэсэн бүрдэл хэсгүүдтэй монгол гэр болон тохижуулсан зөөврийн сууц байна.

### Үндсэн ба туслах түүхий эд материалын хэрэглээ

Барилга угсралтын үндсэн материал болох элс, хайрга, цемент, бетон зэрэг материалуудыг дотоодын зах зээлээс хангахаар төлөвлөсөн. Харин усалтын системийн үндсэн тоног төхөөрөмжүүд болох гол болон хуваарилах хоолой, усалгааны хоолой бусад туслах материалуудыг Хятад улсаас импортлон ашиглахаар төлөвлөж байна.

### Ус хангамж, хэрэглээ

Барилгын ажлын үед ажиллах нийт ажилчдын унд, ахуйн ус хэрэглээг төслийн талбайтай ойр орших сумын гүний худгаас зөөврөөр хангах ба хоногт 1.5 м<sup>3</sup> ус хэрэглэнэ.



### Цахилгаан эрчим хүчний хангамж

Төсөл хэрэгжих талбай нь сумын төвд байрлах тул Сумын ЗДТГ болон бусад холбогдох байгууллагатай зөвшилцөж, зөвшөөрөл авсны үндсэн дээр сумын төвийн цахилгаан эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбогдохоор төлөвлөж байна.

### Дулаан хангамж

Барилгын ажлыг зөвхөн дулааны улиралд явуулах тул дулаан хангамжийн эх үүсвэрт холбогдох шаардлагагүй болно.

### Эцсийн бүтээгдэхүүн

Услалтын системийн барилга байгууламжийг 2022 оны 09 дүгээр сард хүлээлгэн өгч ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн. Услалтын систем ашиглалтанд орсноор 60 га талбайд төмс, хүнсний ногоо, улаан буудай, тэжээлийн ургамал тариална.

Таримлыг төрлөөр нь авч үзвэл 18.9 га талбайд 56.7 тн төмс тариалж 395 тн төмс, 9.1 га талбайд 1.8 тн үр тариалж 36.4 тн тэжээлийн ургамал (эрдэнэшиш, овъёос), 32 га талбайд 6.7 тн хүнсний ногооны үр тариалж 472.2 тн хүнсний ногоог тус тус хураан авна.

### Хатуу хог хаягдал

Ахуйн хаягдал: Төслийн үйл ажиллагаанд нийт 20 хүн ажиллах ба тэдний ахуйн гаралтай хатуу хог хаягдлын хэмжээг тооцохдоо нэг хүнээс хоногт 2 кг хог хаягдал гарна гэдэг жишиг хэмжээг үндэслэн тооцоход 40 кг (20 х 2кг) буюу 1 сард 30 хон х 40 кг = 1200 кг орчим хатуу хог хаягдал гарахаар байна.

### Шингэн хог хаягдал

Ахуйн шингэн хаягдал: Төслийн үйл ажиллагааны үед ахуйн болон цайны газрын зориулалттай хоногт нийт 0.8 м<sup>3</sup>, жилийн хугацаанд 240 м<sup>3</sup> ус хэрэглэхээр тооцоо гарч байна. Үүний 30 %-ийг бохир ус болно гэж үзвэл хоногт 0.24 м<sup>3</sup>, жилийн хугацаанд 46 м<sup>3</sup> бохир ус гарахаар тооцоо гарч байна.

### Хийн хог хаягдал

Төслийн явц дахь агаарын гол бохирдуулагч эх үүсвэр нь төслийн үйл ажиллагаанд ашиглагдах хүнд машин зэрэг байх болно.

## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.2 Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

“Хан Империл” ХХК-ний Завхан аймгийн улиастай сумын нутагт гүйцэтгэгчээр ажиллаж буй "Ногоон хашаа услалтын систем" төслийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолтын хураангуйг энэ хэсэгт оруулав.

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	
Газрын гадарга, байр зүй	Аймгийн Төв Улиастай хот нь Зүүн талдаа хангайн нурууны гол оргил Отгонтэнгэр /4031м/, түүний салбар Тарвагатай, /3227м/ Хуримт, Түдэвтэй, Гурван Халтар, Гялгар, Булнайн /2619м/ нуруу, хойд хилийн дагуу Тагнын нурууны салбар уулстай уулархаг нутагтай бөгөөд баруун хэсэг нь гүвээ толгод, гол хөндий зонхилсон хээр тал нутагтай.
Уур амьсгалын нөхцөл	<u>Ерөнхий төлөв</u> Тус суманд жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар бөгөөд агаарын дундаж температур -28-32 <sup>0</sup> С хүрдэг. Зарим хахир хүйтэн өвөл хангайн нуруу, Тарвагатай, Булнайн, Тагийн нурууны сав нутгаар 49-56 градус хүрч хүйтэрнэ. Үүний учир шалтгаан нь Азийн эсрэг циклон их нууруудын хонхорт төвлөрөн тогтвортой орших хугацаанд хонхор нь их хэмжээний зузаан хүйтэн агаараар дүүрч дороосоо улам жиндэн хөрдөгөөс болдог байна. Голын хөндий хонхор нутгаар өндөрлөг газраас илүү хүйтэн байдаг нь өвлийн улиралын хүйтний горимын нэгэн онцлог юм.
Агаар, дуу чимээ	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн талбайд барилгын ажил явагдах үед олон хүний хөл хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тоосжилт ихээр үүсэх;</li> </ul> <p>Барилгын ажилд ашиглагдаж буй тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг шаардлагагүй тохиолдолд хөдөлгүүрийг унтрааж хэвшсэнээр төслийн талбай болон ойр орчмын дуу чимээ, чичиргээг бууруулах боломжтой. Барилгын ажлын тоног төхөөрөмжийг дуу шуугиан, чичиргээ хамгийн бага тархах нөхцөлтэй газар сонгож байршуулах, дуу чимээ ихээр үүсэх ажлыг зөвхөн өдрийн цагаар хийх зэргээр бууруулах боломжтой.</p> <p>Барилгын ажлын үед их чимээ шуугиан үүсгэдэг объект, тоног төхөөрөмжүүдэд дуу чимээний хэмжилтийг тогтмол хугацаанд хийж, ажилчдад тухай бүрд таниулж, хамгаалах хэрэгслээр хангаж, сургалт зохион байгуулж байх. Барилгын ажлын тоног төхөөрөмжүүдийг ажилчдад үзүүлэх дуу чимээний сөрөг нөлөөлөл нь аль болох хамгийн бага байх зайд байрлуулах хэрэгтэй. Хэт их дуу чимээ үүсгэж болзошгүй ажлыг зөвхөн өдрийн цагаар төлөвлөж хийж байх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>&gt; 1000 Гц-ийн давтамжтай 85 дБА шуугиантай орчинд өдрийн 8 цаг ажиллахад хүний чихний сонсголд хортой нөлөө үзүүлдэг тул үйлдвэрлэлийн ажлыг зохион байгуулах, хамгаалалтын арга хэмжээнд анхаарал хандуулах нь чухал;</li> <li>&gt; Сонсголыг хамгаалах нийлэг бөглөө 10-20 дБА, чихэвч 20-40 дБА нь дуу шуугианыг багасгаж чаддаг тул хамгаалах хэрэгслийг шуугиан ихтэй газарт ашиглах замаар ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлбэл зохино.</li> </ul>
Ус	“Ногоон хашаа” услалтын системийн ус хэрэглээг төслийн талбайгаас 500 м-ийн зайд урсан өнгөрөх Чигэстэйн голоос хангахаар төлөвлөсөн. Чигэстэйн голын урсцыг хамгийн гачиг үеэр нь тооцвол (1.95 м <sup>3</sup> /с) нэг хоногт 168480 м <sup>3</sup> усны нөөц хуримтлагдана. Харин олон жилийн дундаж урсцаар тооцвол (7.61 м <sup>3</sup> /сек) нэг хоногт 657504 м <sup>3</sup> ус хуримтлагдана.
Хөрс	Төслийн талбай нь Хангайн их мужийн өргөргийн бүсшилтэй нутгийн Хангайн дэд муж

	<p>Хангайн өврийн тойрогт хамаарах ба тухайн бүс нутгуудад газрын хотгор гүдгэрийг дагаж тогтсон хөрсний хэд хэдэн хэв шинжүүд тархсан байна.</p> <p>Услалтын системийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ус дамжуулах суваг шуудуу байгуулах, усалгааны тоног төхөөрөмж угсарч суурилуулах, насос станцын барилга байгууламж барих, хөрс боловсруулах зэрэг үйл явцын үед хөрсөн бүрхэвч эвдрэх, хөрсний үржил шим алдагдах, өнгөн хөрсний давсжилт нэмэгдэх, хүний хөл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр өнгөн хөрсний талхагдал нэмэгдэх, шатах тослох материалын цэгэн бохирдол үүсэх, химийн бордоо болон пестицидээр хөрс бохирдох, ахуйн гаралтай органик ба хатуу, шингэн хог хаягдалаас үүдэлтэй механик болон нянгийн бохирдол бий болох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй байна.</p>
<b>Ургамал орчин</b>	<p>Төслийн талбай байрлах Завхан аймгийн Улиастай сумын нутаг дэвсгэр нь А.А.Юнатовын (1946) ургамалжилтын ангилалаар Хангайн уулын ойт хээрийн тойрогт багтдаг. Энд нэг талаас Сибирийн тайгын элементүүд, нөгөө талаас Монголын хээрийн төлөөлөгчид бас Дагуурын элементүүд нэвтэрч байршнаас уулын хээр, уулын ойн бүслүүр ээлжлэн солигдоно. Хангайн нурууны тагд Алтайн-Саяаны өндөр уулын элементүүд нэлээд бий. Эндэхийн нэлээд залуу унаган ургамлуудаас гадна Төвд баягзаваа, их бушилж зэрэг Гимлайн өндөр уулсын үлдвэр ч энд байдаг нь нэн сонирхолтой. Тагдаа бушилзат, өлөн - бушилзат, элдэв өвст намгархаг нугатай хаг, хөвдөт царамтай, тагийн сөөгөн ширэнгэтэй. Уулсынхаа арыг дагаж саруул шинэсэн ой зонхилох боловч Тарвагатайн нуруунд шинэс - Хушин ойтой бөгөөд Булнайн ба Бүтээлийн нуруунд хуш шинэсэн ой нь тайгажуу шинжийг бүрэн үзүүлнэ.</p>
<b>Амьтан</b>	<p>Завхан аймаг нь амьтны газарзүйн мужлалаар Хангайн тойрогт хамаарах бөгөөд энд өндөр уул, ойт хээр, хээрийн бүсийн амьтад тохиолдох тул зүйлийн бүрдлийн хувьд баялаг юм. Баавгай, зэрлэг гахай, бор гөрөөс, буга, аргаль, янгир, ирвэс, чоно, үнэг, хярс, мануул, дорго, шилүүс, туулай, чандага, тарвага, цагаан болон хар сүүлт зээр зэрэг баялаг ан амьтантай. Ойн болон өндөр уулын, тал хээрийн, нүүдлийн шувуу ирдэг. Хойлог, Ятуу, хур сойр, хун, хотон, нислэг сар, тас, шонхор зэрэг ховордсон шувууд бий.</p>
<b>Тусгай хамгаалалттай газар нутаг</b>	<p>Хангайн нурууны байгалийн иж бүрдлийг төлөөлөх ховордсон амьтан, ургамлын унаган нутаг. Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр уулыг анх 1818 онд дархалж байсан түүхтэй бөгөөд 1992 онд Улсын бага хурлын 11 дүгээр тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авч, 1995 онд УИХ-ын 26 дугаар тогтоолоор дархан цаазат газрын ангиллаар баталгаажуулсан байна.</p>

### 2.3 Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт

Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт	
<b>Ерөнхий мэдээлэл</b>	Улиастай сум нь Завхан аймгийн төв бөгөөд ихэнхдээ Улиастай хот гэж нэрлэгддэг. Сумын нутаг дэвсгэр нь бүхэлдээ Алдархаан сумаар хүрээлэгддэг. Засаг захиргааны "Жинст", "Чигэстэй", "Жаргалант", "Богдын гол", "Товцог" "Өлзийт" гэсэн 6 багтай, 0.03 мян.км <sup>2</sup> нутаг дэвсгэртэй. Газар нутгийн хувьд бусад сумдаас хамгийн бага талбайг эзэлдэг. Монгол орны газрын нэгдмэл сангийн ангилалаар нийт газар нутаг нь хөдөө аж ахуйн зориулалттай газарт хамаардаг байна.
<b>Оршин суугчид</b>	Хүн ам: Улиастай сум нь 2019 оны жилийн эцсийн байдлаар 4955 өрхийн 16696 хүн амтай болж өмнөх оноос 0.09 хувиар өссөн байна. Энэ нь аймгийн нийт хүн амын 22.8 хувийг эзэлж байна. Хүн амын 48.1 хувь нь эрэгтэй, 51.9 хувь нь эмэгтэй.
<b>Хүний эрүүл мэнд</b>	Аймгийн хэмжээнд нийт эрүүл мэндийн салбарын 106 байгууллага, 1144 эмч, ажилтан ажиллаж, 49 эмнэлэг, 49 эмийн сан, эм ханган нийлүүлэх төвүүд үйл ажиллагаа явуулж байна. 2019 онд аймгийн хэмжээнд 1357 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1364 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 74 (5.2%)-өөр, амьд төрсөн хүүхэд 67 (4.7)-оор тус тус буурсан байна. Энэ онд ихэр төрөлтийн 15 тохиолдол, амьгүй төрөлтийн 8 тохиолдол бүртгэгдсэн байна. Нийт төрсөн эхчүүдийн 3.7 хувийг охидын төрөлт, 18.5 хувийг 35-аас дээш насны эмэгтэйчүүдийн төрөлт эзэлж байна. 2019 оны 12 дугаар сард 109 эх амаржиж, 110 хүүхэд төрүүлсэн нь өмнөх сараас амаржсан эх 17 (18.5%)-оор, амьд төрсөн хүүхэд 18 (19.6%)- аар өссөн байна. Аймгийн эрүүл мэндийн салбарын бүртгэлээр нас баралтын 379 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна. Нийт нас баралтын 19.3 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж байна. Нялхсын эндэгдэл 2019 онд 22 болж өмнөх оны мөн үеэс 3 (15.8)-аар өссөн байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 29 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2019 онд 16.13 гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчид 2019 онд 710 болж, өмнөх оноос 245 (52.7%) -аар өсч, эндээс бэлгийн замаар дамжих халдварт өвчин 507 болж өмнөх оны мөн үеэс 303-аар буюу 2.5 дахин өссөн байна.
<b>Бусад төсөл</b>	"Ногоон хашаа" усалтын системийн анхны зураг төслийг 94 га талбайг услахад зориулж 1974 онд боловсруулсан байна. Усалтын системийн барилгын ажлыг Завхан аймгийн усны аж ахуйг удирдах газар 1974 онд 94 га талбайтайгаар барьж ашиглалтад өгчээ. Ус дамжуулах гол суваг 4.4 км урт ба 2.3 км урт хуваарилах суваг нь доторлогоогүй. Нийт 93 га талбай усалгаатай тариалалт хийж байсан. Ногооны хашаа усалтын систем нь 93 га талбайг усаар хангадаг боловч одоогоор ердөө 64 га талбайг ашиглаж байна.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

"Ногоон хашаа услалтын систем"-ийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, газар дээр нь ажилласан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн магадлан жагсаах арга, матрицын аргаар тодорхойлсон болно. Энэ үнэлгээг доорх алхмуудаар гүйцэтгэв. Үүнд:

- Байгаль орчны үнэлгээний өмнөх үе шатуудад тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг нарийвчлан тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх;
- Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний (зохих аргачлалын дагуу хийгдсэн) мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх;
- Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшнийг тогтоох нэмэлт судалгаа, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Тухайн төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийхдээ "Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга" (Checklist)-ыг хэрэглэв. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг, бусад гэсэн 5 үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг "сөрөг"=(х), "зэрэг"=(+), "нөлөөлөлгүй"=(0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: "бага зэрэг", "дунд зэрэг", "хүчтэй" гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн болно. Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэн дараах хүснэгтэд үзүүлэв (Хүснэгт 8).

**Төслийн гол сөрөг нөлөөлөл**

**Хүснэгт 1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим**

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуул	Богино хугацаан	Дунд хугацаан	Урт хугацаан	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
<b>1. Байгалийн экосистемийн өөрчлөлт</b>											
Газрын доорх усны чанарт өөрчлөлт гарах		X	X			X		X		X	
Ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах			X		X			X	X		
Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах			X		X			X	X		
Геологийн тогтцын өөрчлөлт	0										
Ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай		X		X				X	X		
Уур амьсгалын бичил өөрчлөлт		X	X	X			X		X		
<b>2. Байгалийн нөөц, ашиглалт</b>											
Газрын гадаргын нөөц баялаг		X	X			X		X		X	
Газрын доорх усны нөөц багасах		X	X			X				X	
Бэлчээр	0										
<b>3. Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											
Гадаргын усны бохирдол		X		X						X	
Агаар бохирдох	0										
Хөрс бохирдох (шатах тослох материал, хог хаягдал хадгал)		X			X			X		X	
Ургамлан бүрхэвч бохирдох (шатах тослох материал, хог)		X			X			X		X	
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>											
Байгалийн үзэсгэлэнт төрх	0										
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	0										
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0										
Түүх соёлын дурсгалт зүйлд	0										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0										
<b>5. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>											
Орон нутгийн орлого нэмэгдэх		+			+					+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг		+			+					+	
Ажлын байр нэмэгдэх		+			+					+	
Төслийн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ		+			+					+	
Нийт (сөрөг/ээрэг)	0/4	8	6	3/4	4	3	1	7	4/4	6	0

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл байхгүй ба эерэг нөлөөлөл 4 байна. Шууд бус нөлөөлөл 8 байна. Нийт сөрөг нөлөөллийн 4 нь бага эрчимтэй, 6 нь дунд эрчимтэй байна. Мөн төслийн зүгээс байгаль орчинд үзүүлж болзошгүй хүчтэй нөлөөлөлд байхгүй байна. Төслийн үйл ажиллагаанаас тухайн хэрэгжиж буй орчныхоо байгалийн нөхцөлд ерөнхийдөө шууд бус, дунд зэргийн болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.



#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төслийн гол зорилго нь орон нутагт нэн шаардлагатай тариалангийн салбарыг дэмжих бөгөөд том хэмжээний талбайг хамарсан нөлөөлөл үүсэхгүй боловч бичил экосистемд бага хэмжээний нөлөөлөл бүрэн арилгаж ажиллах нь зүйтэй юм.

Ажилчдын болгоомжгүй санамсаргүй үйл ажиллагаанаас үүдэлтэй томоохон хэмжээний аюул, осол гарч болзошгүй бөгөөд эрсдэлийн үнэлгээний хэсэгт заасны дагуу технологийн заавар, дүрэм, санамж зэргийг байнга даган мөрдөн ажиллах зайлшгүй шаардлагатай болно.

**МУ-н УИХ-с 2014 онд батлагдсан 43-р тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлогын” 3.3.4.-д байгаль орчинд халтай үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний импорт, хэрэглээг багасгахад чиглэсэн ногоон татварын системийг бий болгох гэж заасны дагуу ногоон үйлдвэрлэл, худалдааг дэмжин ажиллах нь гол юм.**

Тухайн жилийн БОМТ-ний гол зорилтуудыг дараахь байдлаар тодорхойлж байна.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх
- Үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулах
- Гүний усны хяналтын цооногийг байгуулах
- Усан орчны амьтдыг хамгаалах арга хэмжээг авах
- Барилгын ажлын дараахь нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийх
- Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллах

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төлөвлөгөөний гол зорилго нь дээр тодорхойлсон голлох сөрөг нөлөөллүүдийг бууруулах оршино. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа дээрх төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлийн товч тодорхойлолт болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт зэргийг үндэслэн хийв. Зардлын хэмжээг 1 жилээр гаргав.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<b>1. Агаарын бохирдлоос хамгаалах ажил</b>									
1	Төслийн барилгын ажилд ашиглагдах машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Барилгын ажилд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизмын засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх	Барилгын ажилд ашиглагдаж байгаа бүх машин техник, мөн шинээр ашиглагдах бүх төрлийн машин техник	ш	70,000	15	1,050,000	2023	MNS 5013:2003 MNS 5014:2003
2	Барилгын ажлын талбайгаас болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Зам, талбайн тоосжилтыг дарах. Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, тоосжилт дарах өөр төрлийн бодис ашиглах, замыг дагтаршуулах	Барилгын ажил хийгдэж буй бүх талбай	Үйл ажиллагааны төлөвлөгөө, зардалд тусгах			2023 оны 5, 11-р сар	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007	
<b>2. Хөрсний бохирдлоос хамгаалах ажил</b>									
1	Төслийн нөлөөгөөр орчны шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай барилга байгууламж, хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан	Барилгын ажил явагдах талбай болон материалын тээврийн замыг тэмдэгжүүлэх, аль болох бага талбай хамруулан хийж гүйцэтгэх	Барилгын ажилд ашиглагдах шороон замууд	ш	100,000	5	500,000	2023 онд (барилгын ажил дуустал жил бүр тодорхой төлөвлөгөөн ий дагуу арчилж тордож	"Газрын тухай" хууль 50 дугаар зүйл MNS 5914:2008 "Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.

	бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөнө. Барилгын ажлын үед байнгын хөл хөдөлгөөнөөс хөрс, ургамлан бүрхэвч доройтож элэгдэл эвдрэлийн талбай нэмэгдэнэ.							нэмэгдүүлж байх)	
2	Барилгын ажлын явцад хөрсөнд эвдрэл үүсгэх бөгөөд барилгын ажлын хатуу хаягдлын тархалт үүснэ.	Барилгын ажлын үед нэг цэгээс дараагийн цэг рүү шилжих шилжилт тутамд нөлөөлөлд өртөж эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ухаш, овоолго үлдээхгүй байх, хатуу хог хаягдлыг тогтмол түүж цэвэрлэх			Үйл ажиллагааны зардлаас			Цэвэр байх	
<b>3. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах</b>									
1	Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Барилгын ажилд ус авч ашиглах гүний худгуудтай гэрээ байгуулж, усны төлбөр тооцоог холбогдох журмын дагуу хийх	Уст цэгүүд	ш	500,000	2	1,000,000	2023 онд (барилгын ажил дуустал жил бүр тодорхой төлөвлөгөөний баталгаажуулж байх)	MNS0900:2018-Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
2	Усалтын системийн ашиглалтын үед химийн бордоо, пестицидийн хэрэглээ, хадгалалтын нөхцөлөөс хамаарч хөрсний усаар дамжин гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Тариалангийн талбайг тойрсон 3 цэгт тус бүр нь 20 метрийн гүнтэй мониторингийн цооног гаргаж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох Тариалангийн талбайг тойрсон 3 цэгт (Цооног 1- 47°44'28.99"N, 96°50'7.73"E, Цооног 2- 47°44'48.30"N, 96°49'14.21"E,	Цооногуудад	ш	6 000 000	3	18 000 000		

		Цооног 3- 47°44'23.51"N, 96°49'8.51"E)							
3	Усан орчинд амьдарч буй амьтдын амьдрах орчныг өөрчлөх,	Гол суваглах, усан санд загас орвол амьдрах орчны хувьд тохиромжгүй тул толгойн барилгад загас орохоос сэргийлсэн тор тавьж гол суваг руу загас орохгүй дамжин өнгөрөх нөхцөлийг бүрдүүлэх	Төслийн талбайн эргэн тойронд	ш	2 000 000	1	2 000 000	2023	
<b>Нийт</b>					<b>21 000 000</b>				
<b>4. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг багасгах</b>									
1	Төслийн үйл ажиллагаанаас амьтдад	Төслийн үйл ажиллагаанд ан амьтад, мал өртөхөөс сэргийлэн ажиллах	Төслийн талбайн эргэн тойронд	ш	-	-	-	2023	Амьтны тухай хууль
2	үзүүлэх сөрөг нөлөөлөл	Шувуу үргээгч байршуулах	Цахилгааны шонд	ш	100 000	10	1 000 000		
<b>Нийт</b>					<b>3 550 000</b>				
<b>1. Хүн ам, нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг багасгах үйл ажиллагаа</b>									
1		Барилгын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэх хугацаа, хийгдэх ажлуудын талаар иргэдэд мэдээлэл өгөхүйц мэдээллийн самбарыг барилгын талбайн орчимд байршуулах	Төслийн талбайд	ш	300 000	1	300 000	2023	
<b>Нийлбэр дүн</b>					<b>23 350 000</b>				

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллах	мод тарих	Төслийн талбайн гадна	ш Бургас, хайлаас	1000	8 000	8 000 000	2023	
2.	Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг устах, доройтох	Барилга, газар шорооны ажил дууссаны дараа эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих, шаардлагатай тохиолдолд хөрс сайжруулалт хийх зэргээр ургамалжуулах урьдач нөхцөлийг бүрдүүлэх	Төслийн талбай				6 000 000		
3.		Тэгшилж зассан бэлтгэсэн хөрсөнд өрхөг, согоовор, мөлхөө хиаг зэрэг олон наст ургамлын үр тарьж, зүлэгжүүлэх, нөхөн сэргээлт хийх	Төслийн талбай				10 000 000		
<b>Нийт</b>						<b>24 000 000</b>			

## 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

"Хатгал тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах төсөл"-ийн ойр орчимд 3 хиргисүүр буюу түүх, соёлын дурсгалт зүйлс байна. Төслийн барилгын ажлын нөлөөгөөр эдгээр хиргисүүрүүд гэмтэхээс сэргийлэх үүднээс барилгын ажил эхлэхээс өмнө хиргисүүр тус бүрийг тойруулан хайс хашаа барих, түүх дурсгал энд байгаа гэсэн тэмдэг байршуулах шаардлагатай. Барилгын ажил дууссаны дараа хайс хашааг буулгаж, тэмдгийг үлдээх нь зүйтэй. Хэрэв барилгын ажлын үед эртний ургамал, амьтны үлдвэр илэрвэл даруй Палеонтологийн хүрээлэнд мэдэгдэн "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн дагуу авран хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.



8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
<b>Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>									
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс хог хаягдлын төвлөрсөн цэг барих төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Төслийн барилгын ажлын талбай	Өдөр	365	-	Хөвсгөл аймгийн Цаг уур орчны шинжилгээний газрын мэдээллийг ашиглах	2023 он	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль
2	Гал түймрийн улмаас төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн барилгын ажлын талбай	удаа	1	700,000	700,000	2023 он	Галын аюулгүй байдлын тухай хууль
<b>Төсөл хэрэгжүүлэх үед авч хэрэгжүүлэх хөдөлмөр хамгааллын арга хэмжээ</b>									
1	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн барилгын ажлын талбай	Хүн/өдөр			Дотоод төлөвлөлтөөр зохион байгуулах	2023 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Төслийн барилгын ажлын талбай	удаа	1	500,000	500,000	2023 он	
		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн барилгын ажлын талбай	-	-		Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	2023 он	
		Барилгын ажилчдын түр суурин бүрийг анхны тусламж	Барилгын ажлын гүйцэтгэгч	Жил /удаа	1	500,000	500,000	2023 он	

**ХХААХҮЯ-ний захиалгаар Азийн хөгжлийн банкны Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслөөс завхан аймгийн улиастай сумын нутагт хэрэгжүүлж буй "Ногоон хашаа услалтын систем" төслийн гүйцэтгэгч "Хан Империл" ХХК-ны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**2023**

		үзүүлэхэд нэн шаардлагатай хэрэгслүүдээр хангах	байгууллагын ажилчдын хотхон						
2	Ажилчдын хотхоныг зөв зохион байгуулаагүйн улмаас ажилчдын эрүүл мэндэд эрсдэл үүсэх	бие засах өрөө, бусад ариун цэврийн байгууламжыг сар бүр ариутгаж ажиллах	Бүх төрлийн барилгын ажил явагдаж буй талбайнууд, мөн ажилчдын хотхонууд	-	8	50 000	400 000	2023 он	"Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788)" -ийн батлагдсан Байгаль орчны менежментийн ерөнхий төлөвлөгөө
<b>Төслийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нэг жилийн нийт зардал, төгрөг</b>							<b>2,100,000</b>		

## 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь Хэмжилзүй" ХХК-ний Хөвсгөл аймгийн Алаг-эрдэнэ сумын Хатгал тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах төслийн ажлын явцад гарч болох хог хаягдлын эх үүсвэрийг Монгол улс болон олон улсын хууль тогтоомж, стандарт шаардлагын дагуу хянах, бууруулахад чиглэгдэх юм.

Аливаа төслийн үйл ажиллагаанаас үүдэн хог хаягдал үүсгэх нь зайлшгүй бөгөөд холбогдох хууль, журмын дагуу хог хаягдлын менежментийг системийн арга хандлагыг тодорхойлсон болно.

Төлөвлөгөөнд төслийн холбогдох стандартуудыг тогтоох, нөлөөлөл бууруулах арга хэмжээний хяналт шинжилгээ ба аудитын хөтөлбөр зэрэг төслийн хог хаягдлын менежментийн удирдлагуудыг тогтоож өгсөн.

### 9.1 Зорилго

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилгууд нь:

- ✓ Хог хаягдлын менежментийн талаархи дотоодын болон олон улсын хууль, журам, стандартуудыг тодорхойлох;
- ✓ Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны журмуудыг тодорхойлох;
- ✓ Үүрэг, хариуцлагуудыг тодорхойлох;
- ✓ Хяналт шинжилгээ/аудит болон тайлагнах журмуудыг тодорхойлох;

### 9.2 Хууль, эрхзүйн орчин

Хог хаягдлыг цуглуулах, ялгах, хадгалах, боловсруулах, зайлуулахтай холбоотой Монгол улсын болон олон улсын дүрэм журам, стандартуудыг заасан болно.

### 9.2.1. Стандартууд

#### Монголын улсын стандартууд

- ✓ "Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага" MNS 5344 - 2011
- ✓ "Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөв" MNS 6342- 2012 5х

#### Олон улсын стандартууд

- ✓ ЕХ-ны хог хаягдлыг ландфил хийх тухай захирамж 99/31/ЕС (1999 он);
- ✓ ЕХ-ны хог хаягдлыг шатаах устгах тухай захирамж 2000/76/ЕС (2000 оны 12 сарын 4- ны өдөр);
- ✓ ДЭМБ-ын Эрүүл мэндийн салбарын аюулгүй хог хаягдлын менежмент: Бодлогын баримт бичиг, бүртгэлийн хуудас № 281, (эрүүл мэндийн салбарын хог хаягдлын менежмент);
- ✓ Аюултай хог хаягдлын хил дамжсан хөдөлгөөний хяналтын тухай конвенци, хог хаягдлыг устгах конвенци (Базелын конвенци, Монгол улс 1997 онд нэгдсэн);
- ✓ US EPA стандартууд CFR 258 (Хотын хатуу хог хаягдлыг ландфилдэх шалгуур) төсөлд хэрэгжүүлэхээр баталсан;

### 9.2.4. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба менежментийн хяналт

Хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулахын тулд нөлөөлөл бууруулах арга хэмжээ болон менежментийн хяналтыг төслийн ажлын үед хэрэгжүүлнэ. Гэрээт гүйцэтгэгчид нь доорх хүснэгтэнд тодорхойлсон арга хэмжээнүүдийг өөрсдийн ажлын дүрэм журманд тусган дагаж мөрдөнө. Мөн туслан гүйцэтгэгчийн төлөвлөгөөнүүдэд доор дурьдсан шаардлагуудыг дагаж мөрдөхөөр оруулж өгсөн байх ёстой.

"Аюултай хог хаягдал" гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг, "энгийн хог хаягдал" гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг, "ахуйн хог хаягдал" гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг тус тус хэлнэ.

Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр болон үйл ажиллагааны явцад дахин ашиглах, хүнсний хаягдал, үнс болон бусад гэсэн төрлөөр заавал ангилна.

## Энгийн хог хаягдал

Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалж, орон нутагт хамгийн ойр хоёрдогч түүхий эд цуглуулах цэгт хүргэнэ.

Дахин ашиглах боломжтой хог хаягдалд дараах хог хаягдал хамаарна:

- ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/
- ✓ Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/
- ✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл;
- ✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/;
- ✓ Лааз;
- ✓ Мод, модон эдлэлийн хаягдал;
- ✓ Хувцас, даавуун эдлэл;
- ✓ Савхи, резин;
- ✓ Өвс, мод.

Дахин ашиглах боломжгүй хатуу хог хаягдалд дараах энгийн хог хаягдлууд хамаарч байна.

а/ Хүнсний хог хаягдал. Үүнд:

- ✓ Хоолны үлдэгдэл;
- ✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл;
- ✓ Хэрэглэсэн хүнсний тос.

б/. Халаалтын болон уурын зуухны үнс:

в/. Бусад хог хаягдалд дараах хог хаягдал орно:

- ✓ Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- ✓ Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- ✓ Боловсруулсан дахин ашиглах боломжгүй бохир хөрс, шороо, чулуу, элс, хайрга;

- ✓ Хаягдал халдваргүйжүүлэх төхөөрөмжөөс гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал, далан, усан сангийн лав /үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаас гарах лаваас бусад/;
- ✓ Ахуйн болон үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний дахин ашиглах боломжгүй, аюулгүй хог хаягдал;
- ✓ Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал багтана.

Энгийн хог хаягдлыг түр хадгалах цэг нь ангилан ялгах боломжтой, бороо ус орохооргүй, хөрсөнд нэвчихгүй байх шаардлагатай байдаг.

Энгийн хатуу хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээгээр зайлуулах гэрээг байгуулна.

Аюултай хог хаягдал

Оффис, үйлчилгээний газрын үйл ажиллагаанаас төслийн үйл ажиллагаанаас оффисын зориулалтаар ашиглах зарим техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хаягдал буюу ахуйн зориулалтын батерей, принтер, хувилах машины хор зэрэг нь аюултай хог хаягдал болох юм. Иймд эдгээр хог хаягдлыг ахуйн хог хаягдалтай холилгүйгээр тусад хадгалж, эдгээр хаягдлыг хүлээн авах цэгүүдэд нийлүүлэх нь зүйтэй.

Монгол улсад химийн хортой болон аюултай хуванцар хог хаягдлын савыг дахин боловсруулж ашиглах анхны үйлдвэрийг "Цэцүүх трейд" ХХК ашиглалтад оруулсан, ашигласан принтер, хувилах машины хорыг "Электро ВорлдТрейд" ХХК цуглуулан авч, дахин боловсруулж эхлээд байна. Батерей, принтерийн хоронд агуулагдах хүнд металл нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд маш хортой, аюултай хог хаягдлын тоонд ордог. Бидний дунд ашигласан батерейг хазаж, дахин ашиглаж болдог гэсэн ойлголт түгээмэл бий.

Гэхдээ энэ нь хүний эрүүл мэндэд асар их хөнөөлтэй гэдгийг зарим хүмүүс мэддэггүй билээ. Батерей нь асар их хүчтэй хүчил агуулдаг тул ам, хамраа түлэх, улмаар насан туршдаа амт мэдрэхгүй, ярих чадвараа алдаж болох эрсдэлтэй. Мөн төрөл бүрийн хавдар, ургийн гажиг үүсгэх аюултай.

**Хог хаягдлын төрлүүд ба хэмжээ:** Төслийн хүрээнд дараах хог хаягдалд энгийн болон аюултай хог хаягдлын төрлүүд гарахаар байна. Хог хаягдлын гарцын хэмжээг төсөл хэрэгжүүлэгч хог хаягдлын нэр төрөл бүрээр нь холбогдох эх үүсвэр дээр нь ажлын зураг авалт хийж норматив тогтоох шаардлага тавигдаж байгаа. Бид БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ажиллах хүч, ажлын хоног, хэрэглээний норм, техникийн ээлж гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.



**Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ**

Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
<b>Энгийн хог хаягдал</b>		
Дахин ашиглах боломжтой	Цаас	Оффисын 1 ажилтан сард 0.2кг/хүн бичиг цаасны хаягдал
	Шил	Хүнсний баглаа боодлоос 1 хүн/хон*0.6кг
	Хуванцар,	Хүнсний болон ахуйн хэрэглээнээс 1хүн/хон*0.5
	Резин	Техникийн ээлжийн тоогоор тооцно.
	металл, төмөр	Нийт үүсэх хэмжээнээс: <ul style="list-style-type: none"> <li>Ундааны сав баглаанаас 1 хүн/хон* 0.3кг</li> <li>Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарах металлыг тооцоолох боломжгүй байна</li> </ul>
Хүнсний хог хаягдал	(гал тогооны хаягдал)	1 хүн хоногт 0.1кг
Бусад хаягдал	Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	1 хүн хоногт 0.15кг
	Ахуйн хэрэглээнээс гарсан дахин ашиглахгүй шингэн хаягдал	Төслийн хүрээнд унд ахуйд ашиглах усны 90 хувь нь ахуйн бохир болж хаягдана.
<b>Аюултай хог хаягдал</b>		
Батарей аккумулятор	Хар тугалгатай батарей	Батарей солих ээлжийн тоогоор гарна.
Хаягдал тос ба шингэн түлш	Түлшний тос, дизель	Техникийн ээлжийн тоогоор гарна. Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.
Шингэн хадгалах танк, зөөврийн танк, торхны цэвэрлэгээний хаягдал	Тос агуулсан хаягдал	Тос агуулсан хаягдал нь: <ul style="list-style-type: none"> <li>Тос агуулсан арчих материалын хаягдал</li> <li>Тос агуулсан хөрсний хуулдас</li> </ul> Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.
	Хаягдал шингэн катализатор	Тооцох боломжгүй. Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглэнэ.
Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал	Хүнд машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

**Хог хаягдлыг зайлуулах, устгах.** "Хог хаягдлын тухай" хуулийн дагуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах, устгах харилцааг зохицуулах зөвлөмжийг төслийн хүрээнд үүсэх хог хаягдлын нэр төрөл бүрээр авч үзэх шаардлагатай болно. Харин үүссэн хог хаягдлын хэмжээ нэр төрлүүдээр бага, холбогдох эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхөд тээврийн ачааллын хангалттай хэмжээнд хүрэхгүй байж болзошгүй тул төслийн хүрээнд үүсэх хог хаягдлыг нэгдсэн менежментэд шилжүүлж болно гэж үзэж байна.

**Хүснэгт 3. Хог хаягдлыг зайлуулах арга хэлбэр**

Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
<b>Энгийн хог хаягдал</b>	
цаас	Дахин боловсруулах боломжтой тул эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхийн тулд гэрээ хийнэ. Түр хадгалалтын цэгийг хуримтлагдах хэмжээ, тээвэрлэлтийн хугацаатайгаа уялдуулан төлөвлөсөн байна.
шил	
хуванцар,	
резин,	
металл, төмөр	
Хүнсний хаягдал, (гал тогооны хаягдал)	Маш бага хэмжээтэй гарах бөгөөд хэт бохирдолтой, удаан хугацаагаар хадгалах боломжгүй хаягдал тул хамгийн цөөндөө 7 хоногт 2 удаа зайлуулна. Тиймээс эрх бүхий этгээдээр тогтоосон хугацаанд тээвэрлүүлэн зөвшөөрөгдсөн цэгт хүргүүлнэ.
Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	
Шингэн хаягдал	Зөвшөөрөгдсөн цэгт түр хадгалан зөвшөөрөгдөн цэгт зайлуулна.
<b>Аюултай хог хаягдал</b>	
Хар тугалгатай батарей	Аюултай хог хаягдлын зөвлөмжийг баримтална. Эрх бүхий этгээдэд нийлүүлнэ.
Ашигласан тос, масло	Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.
Хаягдал шингэн катализатор	Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглүүлнэ.
Хүнд машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

**Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зардал.** Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг хог хаягдлын нэр төрөл бүрийн менежментийг яаж зохион байгуулснаас хамаарна.

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Ажилчдын хотхон, барилгын ажлын талбай зэрэг бүх төрлийн байгууламжууд	-	100,000	1	100,000	2023 онд	Хог хаягдлын тухай хууль
Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох	Барилгын ажлын талбай зэрэг бүх төрлийн байгууламжууд	-	200,000	2	400,000		Хог хаягдлын тухай хууль
Аюултай	Аюултай хог хаягдлыг кодлон ялгаж бүртгэлжүүлэх, стандартын дагуу хадгалах, нийлүүлэгч талд буцаан өгөх, сав баглаа боодлын хор аюулыг саармагжуулах эсхүл нийлүүлэгч талд буцаан өгөх арга хэмжээнүүдийг тодорхойлох	Барилгын ажлын талбай зэрэг бүх төрлийн байгууламжууд	-	800,000	3	2,400,000		Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль

**ХХААХҮЯ-ний захиалгаар Азийн хөгжлийн банкны Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслөөс завхан аймгийн улиастай сумын нутагт хэрэгжүүлж буй "Ногоон хашаа услалтын систем" төслийн гүйцэтгэгч "Хан Империл" ХХК-ны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**2023**

	Дахин боловсруулах боломжгүй ахуйн хаягдлыг 14 хоногт нэг удаа сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт зөөвөрлөх		500000	1	500 000	
	Дахин боловсруулах боломжтой хаягдлыг нягтаршуулах зориулалт бүхий “хаягдал пресслэгч машин” худалдан авч ангилан ялгасан хаягдлуудыг нягтаршуулан тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх		300 000	1	300 000	
	Барилгын талбайн орчимд үүссэн хатуу хаягдлыг зориулалтын уут саванд хийж, ажил дууссаны дараа түр цэгт ялган хийж орон нутгийн ЗДТГ, байгаль орчны байцаагчийн зөвшөөрсөн цэг рүү тээвэрлэж, орчныг цэвэрлэх	Төслийн талбай	400 000	1	400 000	
	Бохирын цооног суурилуулж, хөрс бохирдуулахгүй ариун цэврийн байгууламж байгуулах		1 000 0000	1	1 000 0000	
<b>НИЙТ</b>					<b>5,100,0000</b>	

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас орчны агаар, ус, хөрсөнд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ОХШХ-т төсөл хэрэгжих газрын агаарын чанар, усны чанар, хөрсөн бүрхэвч, дуу чимээний нөлөөлөл зэрэг хяналт шинжилгээний үзүүлэлт, хэмжилт хийх, дээж авах байршил, хугацаа, давтамж, холбогдох стандарт болон эдгээр ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зардлын төсвийг тооцоолов.

ОХШХ-ыг байгаль орчны мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлж, хяналт тавьж, тухайн бүрт нь тайлагнан ажиллана.

2022 оны БОМТ-нд хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах төслийн ажиллах үед авч хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт **6,545,260** мян.төг зарцуулахаар тусгагдсан. Үүний дагуу ОХШХ-ийг боловсруулахдаа лабораторийн шинжилгээний дараах тарифийг үндэслэл болгов.

### Хүснэгт 4. Лабораторийн шинжилгээний тариф

№	Шинжилгээний төрөл	Үнэ, ₮	Шинжилгээ хийлгэх хугацаа	Итгэмжлэгдсэн лаборатори
1	Агаарын чанарын шинжилгээ (SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO)	23.000	4-р сар	УЦЦОШГ-ын БОХЗТЛ
	Тоосны үзүүлэлт (PM10, PM2.5, TSP)	15.000		
	Техникчийн томилолт	20.000		
2	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	25.000	9-р сар	"Инженер геодези" ХХК
	Хөрсний бохирдлын шинжилгээ (1 дээжинд 6 элемент: Cu, Cr, Cd, Pb, Zn, Ni)	25.000		
	Хөрсний бактерлогийн шинжилгээ	22.000		
3	Ундны усны бүрэн шинжилгээ	43.000	9-р сар	"Монгол ус" ТӨААТҮГ
	Усны бохирдлын шинжилгээ (1 дээжинд 22 элемент)	78.000		
	Усны бактериологийн үзүүлэлт	45.210		

2023 ОНЫ ОХШХӨТӨЛБӨР

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян, төг	Нийт зардал мян, төг	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаар орчин	Агаарын чанарын шинжилгээ Нийт тоос Хүхрийн исэл SO <sub>2</sub> , Азотын исэл NO <sub>2</sub> Дуу шуугиан	Төслийн талбайд 4 байршилд	Төслийн талбайд - Салхин доод талд 20-40 м-ийн бүсэд жилд 2 удаа Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторийн техникчийн хамт гүйцэтгэнэ.	Зөвхөн нийт тоос болон SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> шинжилнэ. 8 дээж * 58 000 = 464 000 Техникчийн томилолт 50 000 төгрөг 1 удаагийн хэмжилт, дээжлэлтийн зардал 514 000 * 2 = 1,028,000	1,028,000	MNS (ISO) 4225:2001 MNS 4585:2007 MNS 3384:1982 MNS 5365:2004 MNS 17.2.316-1988 MNS 3383:1982 MNS5885:2008 MNS (ISO) 5667-4:2001 MNS-4048:88 MNS 6063:2010. MNS 4585:2016), MNS 5919:2008 MNS 5013 :2001 MNS ISO 4221: 2002, MNS 5365:2004
	O <sub>2</sub> , CO <sub>2</sub> , CO, NO, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CxHy/HC, H <sub>2</sub> S, утааны хэм °C, утааны агаарын даралт, утааны хурд м/с	Төслийн ажилд ашиглагдаж байгаа машин техник дизель цахилгаан үүсгүүрүүдийг ялгаруулж буй утаанд нь хэмжилт хийх		15 ш хэмжилт * 58 000 = 870 000*2	1,740,000	
	Тоосны хэмжилт: PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> Тоосны чөлөөт Уналт Тоосны найрлага, бүтэц Тоосны тархалт	Төслийн талбайд 4 байршилд		Зөвхөн нийт тоос болон SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> шинжилнэ. 8 дээж * 58 000 = 464 000 Техникчийн томилолт 50 000 төгрөг 1 удаагийн хэмжилт, дээжлэлтийн зардал	1,028,000	

				514 000 * 2 = 1,028,000		
<b>Хөрсөн бүрхэвч</b>	Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтцын өөрчлөлтийг хянах	Төслийн талбайд 4 байршилд	Төслийн талбайд Нийт 8 цэг /Жилд 2 удаа, 04, 09 сар/	Нэг удаагийн дээжлэлт: 8 цэг* 72 000 = 576,000*2	1,152,000	MNS 3298:1991 "Хөрснөөс шинжилгээнд дээж авахад тавигдах шаардлага" MNS 3297-91 "Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлэлт, үзүүлэлтийн төрөл" MNS 5850:2019 хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>Усан орчин</b>	Ca, Mg, Cl, SO4, NO2, NO3, NH4, HCO3, Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Са-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар,	Төслийн хяналтын цооногууд, Балын арын булгаас дээж авах	Жилд 2 удаа буюу 4 болон 9 саруудад дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө	Нэг удаагийн дээжлэлт: 3 ш дээж* 166,210 = 498,630*2	997,260	MNS 4586:1998 MNS 4079:1988 MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2001 MNS (ISO) 4867:1999 MNS (ISO) 5667-10:2001 MNS (ISO) 5667-11:2000 MNS (ISO) 11083:2001 MNS 4047:1988 MNS 2570:1978 MNS 3936:1986 MNS 0900:2005 (MNS 6148:2010) MNS (ISO) 4867:1999 MNS (ISO) 5667 11:2000 MNS (ISO) 5667-1:2002

	УСНЫ ТҮВШИН					
<b>Ургамал</b>	Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц, % Фенелогийн үе шат Биомасс, цн/га Ургамлын үрийн банк Ургамлын нягтшил 1 м <sup>2</sup> /бодгаль Тоосны тархал	Төслийн талбайд 4 байршилд	Жилд 1 удаа 8 сард	(Нийт 4 байршилд хэмжилт судалгаа) 150,000	600,000	Мониторингийн цэг бүрт судалгааг 25x 25 м2 талбайд 1 удаагийн давталттайгаар хийх
<b>Нийт төсөв</b>					<b>6,545,260</b>	



ХХААХҮЯ-ний захиалгаар Азийн хөгжлийн банкны Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслөөс завхан аймгийн улиастай сумын нутагт хэрэгжүүлж буй "Ногоон хашаа услалтын систем" төслийн гүйцэтгэгч "Хан Империл" ХХК-ны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023







Зураг 4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн цэгүүдийн байршил

## 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аливаа байгууллагын байгаль орчны асуудлыг хариуцах, удирдан зохион байгуулах бүтэц нь ISO 14001 2004 (MNS 2006) стандартад заасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) бөгөөд үүнд тухайн байгууллагын байгаль орчны бодлогын хүрээнд төлөвлөх-хэрэгжүүлэх-хянах-шийдэх гэсэн 4 үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж байгаль орчны үзүүлэлт байнга сайжирч байх нөхцлийг бүрдүүлдэг. Менежментийн тогтолцоонд байгууллагын бүтэц, төлөвлөлт, хариуцлага, практик үйл ажиллагаа, бодлого, дүрэм журмын баримт бичиг, процесс, нөөцийг хамааруулдаг (ISO 14001, 2004).

БОУТ-ны бүрдэл хэсэг, үйл ажиллагааны товч тайлбар:

Байгаль орчны бодлого: Тухайн байгууллагын байгаль орчны үзүүлэлтийн талаар дээд удирдлагаас тогтоосон зорилт, чиглэл юм.

Төлөвлөлт: Байгаль орчны асуудал, хууль журам, стандартын шаардлага, байгаль орчны талаар баримтжуулж, баталгаажуулсан зорилго, зорилт, хөтөлбөр;

Хэрэгжүүлэлт: Хүн, материал, технологи, дэд бүтэц, санхүүгийн нөөц, үүрэг, хариуцлага, захиргаа, ажиллагсдын мэдлэг чадвар, сургалт, харилцаа холбоо, байгаль орчны баримт бичиг болон үйл ажиллагааны хяналт, удирдлага, онцгой нөхцлийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах ажиллагаа;

Хяналт, сайжруулалт: Хяналт шинжилгээ, хэмжилт, гүйцэтгэлийн шалгалт, дутагдал, доголдлыг засах, сайжруулах, сэргийлэх, бүртгэлийн хяналт удирдлага, дотоод аудит;

Удирдлагын хяналт: Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг хянана.

Хэмжилзүй" ХХК-ний Хөвсгөл аймгийн Алаг-эрдэнэ сумын Хатгал тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах төслийн үргэлжлэх явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийг оролцогч талуудад нээлттэй байх гэсэн зарчмын дагуу төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн удирдлага болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал авах зорилгоор тус арга хэмжээнд төсөвлөсөн.

Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэг жилийн зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь ба давтамж	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4	6
Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгоны захиргаатай хамтран төсөлд ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэх, тэднээс ажлын шаардлага хангасан иргэдийг ажлын байраар хангах	Хатгал тосгоны иргэд	Үйл ажиллагааны зардлаас	2023 онд	Төсөл хэрэгжүүлэх нэгж ба гүйцэтгэгч байгууллага
Сум, баг, тосгоны удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах	Төслийн явцыг орон нутгийн удирдлагуудад танилцуулаг	2,500,000		Гүйцэтгэгч байгууллага
Дараа жилийн "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"-г боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулахад бэлэн болгох	Төслийн талбай	Гэрээний дагуу		Гүйцэтгэгч байгууллага
<b>Нийт зардал</b>		<b>2,500,000</b>		

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гүйцэтгэгч байгууллага нь хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаар Хөвсгөл аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газарт хүргүүлэн ажиллана. Мөн бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд нөлөөллийн бүсийн оршин суугчдад хийнэ.

### БОМТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө

БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах нэг жилийн зардал, төгрөг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан ба ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	7	8
Завхан аймгийн байгаль орчин, Аялал жуулчлалын газар	БОМТ-ний биелэлтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэн баталгаажуулах (хэвлэмэл болон цахимаар)	БОМТ-ний биелэлт, хэрэгжилтийн тухай	2023 оны 11-р сарын 5-ны багтаах	1,500,000	Гүйцэтгэгч байгууллага	Аймгийн төв
Улиастай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, ИТХ-аар оруулж танилцуулж, санал авах (илтгэл)	БОМТ-ний биелэлт, хэрэгжилтийн тухай	2023 оны 10-11-р сарын ИТХ-д багтаан хэлэлцүүлэх	1,500,000	Гүйцэтгэгч байгууллага	Сумын төвд
Багийн засаг дарга,	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж хүргүүлэн танилцуулж, санал авах (хэвлэмэл болон цахимаар)	БОМТ-ний биелэлт, хэрэгжилтийн тухай	2023 оны 11-р сарын 1-ны дотор	1,000,000	Гүйцэтгэгч байгууллага	Багийн төвд
Баргийн иргэдийн нийтийн хурал	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гарган танилцуулж, хэлэлцүүлэн санал авах (илтгэл)	БОМТ-ний биелэлт, хэрэгжилтийн тухай	2023 оны 11-р сарын 1-ны дотор	500,000	Гүйцэтгэгч байгууллага	Багийн төвд
<b>Нийт зардал</b>				<b>4,500,000</b>		

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

Урьдчилсан байдлаар тооцож үзэхэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нэг жилд нийт **68 095 260** төгрөг зарцуулах тооцоо гарч байна. Энэхүү хэмжээ нь тухайн жилээс хамааран өөрчлөгдөж болно.

Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ	Тайлбар
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	23,350,000	
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	24 000 000	
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	2,100,000	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5,100,000	
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6,545,260	
Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	2,500,000	
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	4,500,000	
<b>Нийт дүн</b>	<b>68 095 260</b>	

Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан энэхүү тайланд төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ

- A. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- B. Батлагдсан БОМТ-ний нүүр хуудас
- C. Хяналтын хуудас

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тушаал "Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"